

“Хөдөөгийн бүлэг”-ийн удирдагч Өлзийтийн Бадрахын¹ амьдай:

Хятадын КН-ын гишүүн, “большевик”, цахар

Өлзий Бадрахын² тухай

/Түүх – архивын эргэлзээтэй баримтууд/

Г.Ариунболд

Товч утга: Өвөрмонголын харьяат, ХКН, БХК/б/Н-ын зүтгэлтэн, Өлзий Бадрахын намтар.

Түлхүүр үг: Түүхэн хүн судлал

Миний бие Өлзийтийн Бадрахын намтар түүхэнд холбогдох түүх-архивын баримт бичгүүдтэй танилцах явцад Российский Государственный Архив Социально-Политической Истории. Ф.495. оп.152. д.137. л.10-18. хавтаст хэрэг дотор түүх-архивын нэгэн сонирхолтой баримт бичиг олсон нь Ө.Бадрахын нэрээр нэрлэгдсэн нэгэн намтар түүх болой. Энэ намтар эхлээд уншихад чухамхүү Дөрвөдийн Сайн Заяатын баруун гарын чуулганы Зоригт Чин вангийн хошуу, одоогийн Увс аймгийн Давст сумын харьяат, МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга асан Өлзийтийн Бадрахын намтар түүх хэмээн үзэж байхад, яв явсаар энэ хүмүүн нь Өвөрмонголоос угсаа гарвалтай “БХК/б/Н-ын гишүүн, ХКН-ын гишүүн, мөн Өлзий овогтой Бадрах хэмээх байсан нь тун сонирхолтой.

Судлаач доктор Дашдэлэгийн Дашдуламын нэгэн сэдэвт бүтээл болох “Деятельность и концепции представителей левых сил в Монголии /1928-1932 гг./” /Улан-Удэ. 1998. Кандидатская диссертация исторических наук./ хэмээх бүтээлд МАН-ын 3-р их хуралд Хотын ХЗЭ-ийнхэн оролцсон хэсэгт дурьдахдаа зөвхөн “хөдөө”-гийн бүлгийн Ө.Бадрахыг дурьдсанаар хязгаарласан байна. Мөн Ө.Бадрах Солийн Данзангийн талаар хэд хэдэн удаа үг хэлсэнийг дурьдсан хэдий ч, чухам тэр нь яагаад “Би Өвөрмонголоос ирсэн

¹ МАХН дахь “Хөдөө”-гийн бүлгийн удирдагч асан, Өлзийтийн Бадрах нь Дөрвөдийн Сайн Заяатын баруун гарын чуулганы Зоригт Чин вангийн хошуу, одоогийн Увс аймгийн Давст сумын харьяат ажээ.

²Одоогийн БНХАУ-ын харьяат, БХК/б/Н, Хятадын Коммунист Намын гишүүн, Өвөрмонголын иргэн Өлзийтийн Бадрах юм.

хүн” хэмээн сандал дээр гарч зогсоод хэлсэнийг учир битүүлэг, тодорхойгүй орхисон ажээ.³

Харин Магистр судлаач Даваацэрэнгийн Идэр Ө.Бадрахын МАН-ын 3-р их хуралд ХЗЭ-ийн төлөөллийн хамт оролцсон талаар дурьдсангүй. 1924 оны МАН-ын 3-р их хурлын тэмдэглэлээс ажиглан үзэх ахул Өлзийтийн Бадрах нь адил нэртэй, нэг нь БНМАУ-ын харьяат, МАХН-ын зүтгэлтэн хүн бол, нөгөөх нь БНХАУ-ын Өвөрмонголын харьяат, Хятадын болон БХК/б/Н-ын гишүүн, цахар хүн байх ажээ. Ийнхүү МАН-ын 3-р их хурал дээр Өлзийтийн Бадрах нэртэй 2 хүн байсныг үгүйсгэх аргагүй.

Учир нь Солийн Данзанг баривчлан, хэлмэгдүүлсэн МАН-ын 3-р их хурлын үеэр хотын ХЗЭ-ийн бүлэгт чухамхүү Ө.Бадрах нэртэй хүн хэд байсан нь тодорхойгүй ч, харин Солийн Данзангийн талаар үг хэлж, сандал дээр гаран “Би бол Өвөрмонголоос ирсэн хүн” хэмээн сандал гарч зогсоод хашгирч байсан⁴ нь Коминтерны даалгавраар хурлын үйл ажиллагааг саатуулах зорилго бүхий “Өвөрлөгч” гаралтай мөн л Өлзийт овогтой Бадрах хэмээх хүн байх магадлалтай нь тодорхой билээ.

Дээрхи өвөрлөгч Ө.Бадрахын талаархи хоёр дахь мэдээ бол - Турар Рыскулов нарын зэрэг МАХН, Монгол, Зөвлөлтийн төлөөлөл 1925 оны үеэр Хятадад хүрэлцэн очиж, генерал Фын Юй Сянтай нууц уулзалт хийх үеэр тэдний орчуулагчаар нь чухамхүү Өлзийн Бадрах хэмээх БХК/б/Н-ын гишүүн, Хятадын коммунист /магадгүй Коминтерний даалгавар, оролцоотой/ туслан орчуулж явсан нь нэн сонирхолтой.

“Цахар” Өлзийн Бадрахын гэргий хэмээсэн хүний нэгэн дуртгал МАН-ын Төв Архив дахи МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга асан Өлзийтийн Бадрахын хавтаст хэрэгт санамсартай, санамсаргүй нь мэдэгдэхгүй орсон нь гайхал төрүүлнэ.

Овог, нэр ижил, амьдрал, намтар, түүхэн замнал, хувь заяагаар адил төстэй зүйл бүхий хэдий ч, мөн бусдаараа өөр ялгаа бүхий “цахар” угсааны Ө.Бадрах болох нь түүний намтараас нь тун тодорхой харагдах ажээ.

Цахар Ө.Бадрахын гэргийн дуртгалд⁵ өгүүлсэнээр бол, “Би 1928 оны сүүлч, эсвэл 1929 оны эхээр Ленинградд Өлзийн Бадрахтай танилцсан. Өдөр бүр уулзалдсаар 1930 онд гэрлэсэн⁶” гэжээ. “Хөдөө”-гийн бүлгийн удирдагч

³ Дашдэлэгийн Дашдулам “Деятельность и концепции представителей левых сил в Монголии /1928-1932 гг.” Улан-Удэ. 1998. Кандидатская диссертация исторических наук.

⁴ МАХН-ын 3-р их хурал, УБ., 1966, т. 190.

⁵ Улс төрийн хэлмэгдэгсэдийн баримт бичгийн товчоон., “Өлзийтийн Бадрах, Ширзанын Эрэнцэнг хэлмэгдүүлсэн тухай”.. Гутгаар боть, УБ., 2011, Ө.БАДРАХЫН ТОВЧ НАМТАР №4, Ө.Бадрахын гэр бүлийн хүний бичсэн намтар., т. 177-179. МУУТА. МАХН-ын Баримтын Төв. Х-Ц 6. Д-1. ХН-4.

⁶ Өлзийтийн Бадрах нь 1915 онд Дөрвөдийн Сайн Заяатын баруун гарын чуулганы Зоригт Чин вангийн хошууны бүсгүй Сөмбөө /буюу Самбуутай/-тэй гэр бүл болсон ажээ. Тэгэхлээр энэ дээр

Ө.Бадрах нь Ленинградд Монголын анхны парламентын төлөөлөгчдийн хамт айлчилж байснаас, мөн үед МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргаар сонгогдон ажиллаж байсан билээ.

Мөн тэрвээр дуртгалдаа цааш нь өгүүлэхдээ: “Ленинградд түүний тухай надад төдийгүй, миний бүх төрөл саданд “ажилчид ба намынхан” хамгийн сайхан сэтгэгдэл төрсөн бөгөөд тэрээр утга учиртай амьдралтай, коммунист тогтсон үзэл бодолтой, Лениний жанжин шугамыг хатуу мөрдөгч байсан. Энэ нь түүнтэй ярилцахад төдийгүй, түүний байгаа байдлаас харагдаж байсан. Яагаад гэвэл цаг хугацаа үнэн хэрэгтээ тэр хэн бэ?, тэр юугаар амьдарч, амьсгалж байгааг харуулсан” гэсэн нь буй. Үүнээс үзэхэд хоёр Ө.Бадрах нь аль аль нь “коммунист” чиг шугамыг барьсан, “большевик” тогтсон үзэл бодолдоо үнэнч хүмүүс байсан бололтой.

“Цахар” Бадрахын гэргийн дурьдсанаар: “Ө.Бадрахын нэг бус удаагийн дуртгалаас түүнийг үе дамжсан ядуу ард байсныг би мэдсэн. Түүний эх нь түүнийг 6-7 настай байхад нь нас барж, нөхөрт гарсан эгч нь өсгөжээ. Амьдрал хүнд, ядуу зүдүү байдлын улмаас хүргэн ах нь илүү ам тэжээж байгаад нь эхнэрээ буруутгах болжээ.

Ө.Бадрахыг хийгээгүй хэргийн төлөө ч зодож шийтгэх болжээ. Ө.Бадрах эгчийнхээ жижиг хүүхдийг асрах ажлыг хийх болж, аж ахуйд нь туслаж байв. Гуталгүй тул эгчийнхээ алчуураар нэхсэн шаахайг өмсөн, цамц нөмрөхийг мэдэхгүй өсчээ. Ийнхүү 14 нас хүртлээ ийм амьдралыг туулжээ. 14 нас хүрэнгүүтээ бие даан амьдрах болж, суралцахаар шийдэн Бээжинд явж⁷ очсон байна” гэжээ. Тэгвэл МАХН-ын зүтгэлтэн Ө.Бадрах нь Бээжинд явж суралцаж байсангүй, идэр залуу наснаас үе уламжилж ирсэн сумын занги⁸, мөн хошууны тамгын газарт бичээчийн алба хашиж ирсэн түүхтэй.

Өвөрмонгол Ө.Бадрахын талаар дурьдахдаа: “Тудамжаар өлсгөлөн тэнүүлчлэх түүнийг зөөврийн дугуй түрээслэгч нэгэн өрөвдөн, өөд татаж, түүнд өдөрт 10 коп. хөлстэйгээр зөөврийн дугуй өгчээ. 7 наснаасаа л ядуу зүдүү амьдарч ирсэн Ө.Бадрах 14 насандаа өөрөө хоолоо олж идэх болжээ. Жижигхэн, сул дорой хүү - морь мэт зүтгэн, хүнд, тарган ноёдыг зөөвөрлөх болсон байна. Ийм маягаар 4-5 сар өнгөрчээ. Ямар ч байсан сурах бодлоо орхилгүй явсаар сангийн мөнгөөр сургуульд монгол-төвд бичиг суралцах

яригдаж буй Ө.Бадрах бол Өвөрмонголын Ө.Бадрах мөн болно. “Улс төрийн хэлмэгдэгсэдийн баримт бичгийн товчоон”.. “Өлзийтийн Бадрах. Ширзанын Эрэнцэнг хэлмэгдүүлсэн тухай”.. УБ.. 2011.. т. 177-179.

⁷ МАХН-ын зүтгэлтэн Ө.Бадрах нь хэдийгээр Ленинградд очиж байсан хэдий ч, тэнд суралцаж байсангүй. Тэрвээр эхнэртэйгээ Увс аймгийн нутагт 1915 онд танилцан сууж гэр бүл болцгоожээ. Мөн Ө.Бадрах нь үе уламжилсан сумын занги байсан бөгөөд хэзээ ч айлд зарцлагдаж байгаагүй, бас Бээжинд очиж суралцаж байгаагүй юм.

⁸ Зарим сурвалжид мөн мэйрэнгийн алба хашиж байсан гэсэн нь буй. “МЗЭ-ийн 50 жилийн ойд зориулсан зохиолчдын каталог”. УБ. 1971 он.

болжээ. Гэтэл ийм нэгэн явдал болжээ. Курсант- нөхдүүд нь Өвөр Монголын хэсэг газар нутгийг хувийн капиталист сонирхолын үүднээс өгч, ард түмнийг улам бүр боолчлох болсныг мэдээд хамт даа нөгөө тайжийн гэрт очиж, ард түмнээ өрөвдөн хайрлаж, ийм зүйлийг хийхгүй байхыг гуйхаар шийджээ. Ө.Бадрах тэдний дунд оров. Тэдний хүсэлтийг сонссон тайж зэвүүнээр хөхрөн, тэр эзэн эрх мэдэлтэй юу хүссэнээ хийнэ хэмээн хариулжээ. 15-16 орчим настай байсан Ө.Бадрах биеэ барьж дийлэлгүй, хаалганы дэргэд байсан том саваа модыг авч, нөгөө харгис “Эзэн-капиталист”-ын дагзанд буулгаж орхижээ. Тайж тэр дороо унан, курсантууд зугтаж, харин Ө.Бадрахыг харуул барьж авч, хайр найргүй зодож, шоронд хорьчихожээ. Шоронд нэлээд зовлон амсаж, шоронгоос гараад дахин унтах ор, хоол хүнсгүй явжээ. Тэрээр зөөврийн дугуй түрээслэгч хуучин танилаа санаж, түүн дээр очиход, энэ удаад зөөврийн дугуйнд 15 коп. төлөх болжээ. Ийнхүү хүн-мориний хүнд хүчир ажилд дахин нухлагдах болжээ. Энэ хүнд ажилд 5-6 сар зүтгэжээ.

Тэрээр дахин суралцахыг хүсч, энэ удаад сонсогчоор элсэж, зав чөлөөгөөр нь гудамжинд сонин зарж амьдрах болсон. Удалгүй нөхдийн тусламжтайгаар хэвлэлийн газар ажилчнаар оржээ. Энд тэрээр цаашдын зорилгоо тодорхойлон, энд түүний үзэл бодол төлөвшин, зөв замдаа оржээ. Тэрээр нууц байгууллагын гишүүд-ажилчидтай нягт холбоотой болж, тэдэнд үнэнч ажиллаж хажуугаар нь Ө.Бадрах сонины газартаа идэвхтэй ажилласаар байв. Удалгүй болгоомж алдсан уу эсвэл, хов хүрсэн үү 8 хүн баривчлагдан, тэдний дунд Ө.Бадрах бас баригдаж шоронд оржээ. Энэ хувьсгалч-ажилчинд капиталистын шоронд хоригдох нь амаргүй байсан биз. Тэд сул чөлөөтэй байсан үзэл бодол нэгтэн - найз нөхдийнхөө ачаар, бас Бээжинд засаг төргүй үймэж байсан цаг үеийн ачаар шоронгоос гарчээ” гэжээ. Дээрхээс үзэхэд энэ хүн нь Өвөрмонголоос ирсэн хүн болох тодорхой болой. Гэхдээ энд нэг адил зүйл байгаа нь МАХН-ын Ө.Бадрах ч гэсэн хойно “Гадаадын ажилчин “улс төрийн хэвлэлийн газарт консультантаар ажиллаж байсан явдал юм.

Дурьтгалд бичсэнээр: “Ө.Бадрах эрх чөлөөтэй болонгуут нөхөд нь ажлаа үргэлжлүүлэхийн тулд хувьсгалт Монголд очихыг зөвлөн, тийшээ илгээхээр шийджээ.

Ийнхүү 1925 онд⁹ Ө.Бадрах Монголд ирж, намын сургуульд сурч¹⁰, улмаар ЗХУ-д суралцахаар явжээ.

⁹ 1924 онд болов уу, учир нь Өвөрмонголын Ө.Бадрах нь МАН-ын 3-р их хуралд оролцох доо Солийн Данзанг МАН-ын ТХ-ны даргын албан тушаалаас буулган, улмаар Хотын ХЗЭ-ийн гишүүдийн төллөлтэй хамтаар түүнийг ХЦЗ-ийн үүрэгт ажлаас буулган, Ринчино, Дамбадорж, Х.Чойбалсан нарын хуйвалдаанд оролцоход хүрсэн ажээ.

¹⁰ Цахар Ө.Бадрах нь 1924 онд намын идэвхтний сургуульд Улаанбаатар хотноо суралцаж байх үе дээ МАН-ын 3-р их хурал дээр Хотын ХЗЭ-ний идэвхтнүүдийн хамтаар Солийн Данзанг

“Ө.Бадрах Ленинградд хэрхэн амьдарч байсан бол? Би түүнийг 1929 оноос мэдэх боловч түүнийг олон жил мэдэх хүмүүс Намнандорж, Равдан зэрэг бий гэж бодож байна. 1930 онд Ө.Бадрах Ленинградд намын цэвэрлэгээнд орж, ямар ч шийтгэл хүлээгээгүй. Энд Ө.Бадрахтай хамт нэг жил хагас амьдрахдаа би Ө.Бадрахын тухай дээр миний дурдсан сэтгэгдэл улам бүр батжисаныг зоригтойгоор хэлж чадна. Тэрээр шаргуу хөдөлмөрлөгч, өөрийн идэвх, үзэл бодлоосоо үл ганхагч, ажилчин ангид үнэнхүү үнэнч гэдгээ харуулсан” хэмээн цахар Ө.Бадрахын гэргий дурьтгалдаа хэлсэн байна.

Цахар Ө.Бадрахын тухай бас нэгэн баримт бол академич Ж.Болдбаатарын МУИС-ийн “Эрдэм шинжилгээний бичиг”-т хэвлүүлсэн “Амар, МАХН-ын төлөөлөгчид Фын Юй Сянтай хийсэн хэлэлцээрийн тухай Рыскулов, Линде нарын илтгэх хуудас”¹¹ билээ. Түүний дотор дурьдсанаар, “/Маш нууц. Коминтернд – дорнодын хэлтэс/ Нөхөр Петровт гэсэн баримтанд дурьдсанаар “Эцэстээ төлөөлөгчдийн бүрэлдхүүнийг ес хүртэл нэмлээ. 1.Төлөөлөгчдийн дөрвөн гишүүн, 2.Орос-монгол орчуулагч /буриад Галон/, монгол-хятад орчуулагч /Бадрах, тухайн үе дээ Бээжинд оюутан байсан бөгөөд хятад хэл сайн ойлгодог Өвөр Монгол цахар/, 3. Амар ба Цэцэн ханы хувийн бараа бологчид, 4. Мөн нарийн бичгийн даргаар хятад хэл бага сага мэддэг Дамбадорж ах нар тус тус орсон болно” гэжээ.

Мөн “Тэглээ ч гэсэн мордохынхоо өмнө Гэлэгсэнгэ орчуулагч Бадрах нарыг бид энд ирсэн тухайгаа Фыны шадар хүмүүст мэдээлэх, цааш явсан даа уучлал гуйлгахаар илгээжээ. Тэд Фын-ы түшмэдүүдийн хэн нэгэнд үүнийг уламжилсан боловч түүний хувийн нарийн бичгийн даргыг олж уулзаж чадаагүй”¹² гэсэн нь буй.

Мөн “Фыны талын эдгээр хүмүүс завсарлагаар төлөөлөгчдийн бүрэлдэхүүн болон бусад асуудлын талаар нарийн ширийн зүйлийг орчуулагч Бадрах болон хоёрдугаар зэргийн хүмүүсээс мэдэх гэж элдвээр оролдож байсан нь аяндаа илэрхий. Жишээ нь, тэд та нарын хэн чинь орос хэлний орчуулагч юм бэ гэж, өөр бусад асуулт тавьдаг байв” гэж байв. Мөн “Тэр ч бүү хэл орос сургагчдыг урьж болно” гэж ярьж байсан ба Фынд зориулж Цахараас арван хүнийг шилж авахыг бас орчуулагч Бадрахад санал болгож байв”¹³ гэсэн байна.

МАН-ын дарга, их хурлын даргын албанаас буулгах Ринчиногийн улс төрийн зохиомол ажиллагаанд оролцож, их хурал дээр ёс бус аашилж байсан байна.

¹¹ Монгол Улсын Их Сургууль, ТҮҮХ VIII., сэтгүүлд., 2009 оны №317/53/. 236 дахь тал.

¹² Мөн дээрх, т. 237.

¹³ Мөн дээрх, т. 247.

Энэхүү түүх-архивын баримтын зэрэгцээ сонирхол татахуйц бас нэгэн түүхэн баримт байгаа нь "МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Ө.Бадрахын И.А.Пятницкий болон Мифэд илгээсэн "баруунтантай" нам болон Засгийн Газрын зүгээс хийх тэмцлийн тухай болон экспорт-импортын төлөвлөгөө болон 1932 оны улсын төсвийн асуудлын талаар авах арга хэмжээний тухай, феодалуудын өмчийг хураах тухай болон бусад асуудлын тухай. Хятадын Коммунист Намын төлөөлөгчийн үйлдлийн талаархи баримт бүхий захидал. 1932 оны 3-р сарын 5. Маш нууц." хэмээх захидал юм.

Тэрхүү захидлын орос эх болон монгол орчуулгыг танилцуулъя.

"Письмо секретаря ЦК МНРП О.Бадархо И.А.Пятницкому и П.А.Мифу о борьбе с "правыми" в партии и правительства по вопросу о принятии Экспортно-импортном плана и госбюджета на 1932 г., о конфискации имущества феодалов и др. Инциденте с представителем китайской компартии.

5 марта 1932 г.

совершенно секретно **корректировка**

Письмо секретаря ЦК МНРП О.Бадархо И.А.Пятницкому и П.А. Мифу о Попытках ревизии решении партии по вопросу о принятии экспортно-импортном плана и госбюджета на 1932 г., о конфискации имущества феодалов и др.

5 марта 1932 г.

совершенно секретно

После отъезда тов. Черномордика у нас в ЦК усилилась попытка ревизии решений ЦК, вынесенных за последний год. Попытка эта исходит со стороны отдельных членов ЦК т.т. Демид, Жигжитжап и др. ранее согласных с линией партии по ряду важнейших принципиальных вопросов. Поэтому я считаю своим партийным долгом поставить вас в известность об этих попытках.

Попытка ревизии решений ЦК пока, что вертится вокруг таких вопросов: экспортно – импортный план, имущество феодалов и др. Постараюсь вкратце рассказать вам о позициях этих товарищей и линии ЦК по этим вопросам. Если информация будет недостаточно полна, то рекомендую вам поговорить по затронутым мною вопросам с тов. Черномордиком, который хорошо знаком с общей линией ЦК.

Вопрос об экспортно-импортном плане. Вопрос об экспортно-импортном плане у нас значительное время является спорным, несмотря на определенное решение ЦК по этому вопросу. Исходным моментом этого спора

является оппортунистическое неверие в возросшую хозяйственную мощь страны в результате наступления на феодалов и борьбы за некапиталистический путь развития страны. Правые оппортунисты не хотят согласиться с максимальным вариантом экспортно-импортного плана 1932 г. Они для того, чтобы оправдать свои оппортунистические позиции, пустили в ход контрреволюционную версию о том, что заготовки в 1931 г. были проведены методами административного нажима со стороны партии и заготовительных организаций на аратское население страны. Именно об этих оппортунистических, ревизирующих линию партии, говорится в письме ЦК и ЦКК МНРП ко всем членам и кандидатам партии по поводу созыва IX съезда партии о том, что : "Если оппортунист до и во время VIII съезда партии являлся прямым защитником феодала и монастыря, выступая против передачи на выпас аратом и колхозникам джассовского скота, то теперь отрицает выросшую хозяйственную мощь страны и творческую инициативу масс. Если оппортунист до и во время VIII съезда партии распространял контрреволюционную теорию о деградации аратского хозяйства, то теперь он утверждает о нереальности планов хозяйственного строительства и отрицает рост производительных сил революционной Монголии. Если оппортунист до и во время VIII съезда партии с открытым забралом боролся против линии партии, то теперь он двурушничает по отношению к партии, т. е. на словах голосуя за то или иное решение партии, а на деле всячески саботирует его осуществление. Партия должна ударить самым решительным образом по двурушничеству, как новому замаскированному методу борьбы оппортунистов против генеральной линии партии. Письмо ЦК и ЦКК МНРП ко всем членам и кандидатам партии по поводу созыва IX съезда партии, постановление ЦК утвердило максимальным вариант экспортно-импортного плана. После принятия этого постановления ЦК некоторое время, те которые были не согласны с этим решением, замолчали. Можно было предполагать, что они подчинились решению партии. Но на деле получилось не так. После приезда из Москвы т. т. Джигжитжап и Соднома эта группа значительно активизируется и повела открытый поход против решений ЦК. Правительство до сего времени не провело решение ЦК об увеличении экспортно-импортного плана. Так можно издеваться над решением ЦК? Таким поведением можно воспытывать партийцев вокруг принципиально правильной линии партии, я считаю, что этого делать нельзя. Такое поведение, как у т. т. Джигжитжапа, Демида и Соднома, есть ни что иное как издевательство над линией партии, есть двурушничество. Недаром эта группа товарищей считает, теперь одной характерной особенностью в нашей партии является двурушничество, когда партиец в худоне после единогласного

принятия решения по тому или другому вопросу. Когда он остается в меньшинстве, не выступая открыто на самом собрании умалчивая свое несогласие с решением, идет в массы и говорит о том, что он был не согласен с такими — то решениями ячейки, что он все равно не будет выполнять их. “Рекомендую последовать — говорит аратам — моему примеру”. Такое поведение партийца надо назвать не иначе как двурушничеством. Не есть ли двурушничество, когда руководящий работник аймака, присутствуя на заседании айкома по его работе, после в своей практической работе не выполняет это решение. Такое поведение партийца нельзя иначе называть, чем двурушничеством. Не есть ли двурушничество, когда член ЦК оставшись не согласным с решением ЦК по вопросу, касающемуся к той отрасли работы, где он является руководителем, после принятия решения ЦК не только саботирует его, но вообще плюет на это решение ? Такое поведение члена ЦК нельзя называть иначе, чем двурушничеством. Прошу вас, т.т. Пятницкий и Миф, обратить ваше внимание на этот вид оппортунизма в нашей партии. По моему глубокому мнению, не борясь с этим видом оппортунизма. Мы не сможем защитить генеральную линию партии от правого оппортунизма, как главной опасности, так и от левых загибов и примиренчества к этим уклонам.

Вопрос о феодалах и их имуществе. ЦК нашей партии, исходя из решений VIII съезда и I партконференции, поставил перед партией задачу нанести решительный, смертельный удар феодализму до IX съезда партии. Исходя из этой установки, мы приняли решение закончить до конфискацию феодалов и разобрать все дело феодалов форсированным темпом, как через особые комиссии. ГВО, так и через судебные органы. Те же товарищи, которые были против решения ЦК о феодалах. Решение ЦК не выполняется, всячески тормозится. Тормозится, главным образом, судебными органами, возглавляемыми явными оппортунистами, бывшими чиновниками вроде Ламажапа и др. По вине этих оппортунистов до последнего времени содержалось в монгольских тюрьмах больше батраков и бедняков, чем феодалов и чиновников. ЦК принял определенное решение об оргвыводе по отношению этих саботажников, но опять саботируется группой Джигжитжапа, Демида и др. Возглавляемыми партийную фракцию Правительства.

Теперь делается новая попытка со стороны этой группы вообще ревизовать решение ЦК о феодалах. Товарищи эти теперь хотят задним числом всю вину переложить на ГВО. Нужно ли нам сейчас и вообще в будущем какая — бы то ни было дискредитация этого важнейшего органа — революционной власти — ГВО. По моему глубокому убеждению, те товарищи,

которые попытаются дискредитировать и развенчивать ГВО и его аппарат, делают серьезную политическую ошибку.

Теперь это группа товарищей по совету тов. Охтина, настаивает на механической передаче всего имущества феодалов Военному Министерству. Тов. Охтин специально приезжал ко мне и в беседе настаивал провести через ЦК решение о передаче имущества феодалов Военному Министерству. В проекте резолюции, которую эти товарищи предлагают принять, пишут, что это делается якобы чуть ли не по требованию аратства и партийцев. На самом деле далеко не так обстоит дело. Такого требования еще не было и нет пока с низов. По моему мнению, механическая передача имущества феодалов Военному Министерству, притом бюрократическим методом, т.е. дискредитированием сверху, будет вредна и ошибочно. Надо показать реальную пользу аратам и колхозникам, что они заинтересованы в ликвидации феодалов, что они дрались за свою власть. Надо передать Военному Министерству не все, только часть имущества, при том не бюрократически, не дискредитированием сверху. Если надо увеличить военный бюджет, а этого обязательно нужно сделать, то нужно это увеличение военного бюджета произвести за счет общегосударственного бюджета. По моему мнению, мы сумеем отстоять независимость от японских и иных империалистов не только тем, что наши красноармейцы будут хорошо обеспечены и вооружены, но и тем, насколько крепок будет тыл нашей Революционной Красной Армии. Трудящиеся араты и колхозники, дерущиеся против феодалов, если не получат кое-что от феодального добра, то определенным образом будут обескуражены. Такова моя позиция о феодалах и их имуществе. Пока ждем указанный от ИККИ. Какая будет директива, я подчинюсь и буду проводить ее в жизнь.

Вопрос о госбюджете. Только вчера утвердили госбюджет в сумме 39 млн. тгр. В бюджетной комиссии та же группа товарищей, о которой я говорил выше, настаивала увеличить налог на середняков и брать налог от колхозников за необобщественное имущество. Пока такое предложение провалили. Увеличение налогов середняков будет играть на руку феодалов и интервентов. Брать налог от колхозников за необобщественное стадо выгодно ли сейчас. Я думаю, что это не выгодно. Эти товарищи портили слух о том, что наши колхозы являются такими же эксплуататорами, как кулаки, заявление тов. Лхумбэ. 4. Это есть новая правоопортунистическая клевета на колхозы. При утверждении бюджета срезали бюджет партии на 600 тыс. рублей, такое уменьшение бюджета партии означает полное свертывание издания массовой литературы и литературы по марксистско-ленинскому воспитанию партии. Бюджетная комиссия Правительства предложила срезать бюджет партии, мне пришлось специально вызвать Пред. Монголбанка и Советника Минфина тов.

Львова и поговорить с ними по этому вопросу. Тов. Львов заявил мне, что он в бытность свою в партии на протяжении 25 лет еще ни разу не видел подобного явления, когда руководящей государственной партии срезали партийный бюджет и нарушали нормальный ход работы. Но он заявил, что он тут ни при чем, он лично за то, чтобы увеличить партийный бюджет, но дело не от него зависит. Тов. Львов обещал в случае критического положения с бюджетом партии помочь достать нужные средства.

Вероятно, теперь в связи [с] сокращением бюджета партии, лишимся возможности ежедневного выпуска газеты, что добились в прошлом году, с большими напряжениями. Придется приостановить регулярный выход крайне необходимого партийного журнала, сократить выпуск партийно-массовой литературы.

Вопрос о приехавшем от Вас китайском товарище тов. Ченземин по другой фамилии Лючисан пришел в ЦК ко мне сразу же в день прилета в Уланбатор. Несчастье его заключалась в том, что он каким то образом подцепил к себе переводчиком одного внутреннего монгола, некоего Ульдзе-Бадархо, который у нас был под подозрением как возможный агент японского империализма. При первой беседе я заявил т. Лючисану, что у нас пока что нет никаких извещений от Коминтерна и что я запрошу Коминтерн и после получения ответа буду вести с ними беседу. В тот же день просил Н.Охтина своим шифром запросить Москву. После этого через три дня н. Охтин заявил мне, что он получил телеграмму от Коминтерна, и подтверждает, что такой товарищ послан через МНР в Китай для связи с 29-м корпусом Китайской Красной Армии.

При этой беседе присутствовал тов. Нацов, который, вероятно, помнит нашу беседу с тов. Охтиным.

После этого я договорился [с] двумя другими секретарями ЦК. т.т. Демид и Лувсаншарав о том, что нужно помочь в дальнейшей поездке этого китайского товарища. Тем временем дело приняло совершенно другой оборот. Через 2-3 дня после моей беседы с т. Охтиным и с приехавшим китайским товарищем появляется группа т. т. А именно Намсрай (Нач. ГВО), Дубровский (Зам. Инструктора ГВО), Шеко (Нач. Глав.), т. т. Демид и Джигжитжап требуют ареста этого китайского товарища, как японского шпиона. Просил я этих товарищей, чтобы прежде чем арестовать, поговорить с т. Охтиным, у которого имеется телеграмма Коминтерна и ЦК Киткомпартии.

Приехал на следующий день ко мне т. Охтин для разговоров по разным вопросам. В беседе я спросил т. Охтина, что он знает об аресте китайского товарища. На мой вопрос он ответил, что он все знает, что правильно поступил т. Дубровский, провел его арест. Тов. Охтин заявил мне, что приехавший из

Москвы китаец, оказался, как он выражался очень тонким японским шпионом. Я был поражен этим сообщением, так как только несколько дней тому назад Коминтерн телеграфировал, что он является их человеком, а теперь он оказался "очень тонким японским шпионом". Предполагал я тогда, что должно быть обманулись в этом китаец и Коминтерн, и ЦК МНРП (в частности я который с ним вел беседу). Но вся же таки я решил сам запросить Коминтерн через т. т. Гендун и Чижия, находившихся в Москве. Получил телеграмму от Гендуна и Чижия о том, что они говорили в Коминтерне убедительно просят помочь Монгольской Партии пробраться в Китай. Теперь, кажется получили телеграмму т. Дубровский и Охтин по своей линии и [о] этого китайского товарища дальше. Теперь освободили его из под ареста. Преотправим его дальше через несколько дней.

Если этот человек действительно является работником Коминтерна и ЦК Киткомпартии, то получился величайший конфуз. По моему мнению [за] задержку и арест этого товарища отвечают т.т. Охтин и Дубровский. Пару слов о деле Лагана. Недавно один из работников ГВО, некто Гевапил, подал заявление в ЦК на т. Лагана о том, что [он] виновен в целом ряде преступлений. По получении этого заявления я, как один из секретарей ЦК, вызвал т. Лагана и заявил ему в очень резкой форме свой протест, против его поведения.

При этой моей беседе присутствовал т. Лопсанширап. Т. [ов] Лагон категорически отвергает те обвинения, которые на него возвел Гевапил. Переводим заявления, и со всеми дополнительными, материалами вышлю вам со следующей почтой. Пока на этом кончаю свое письмо. Просьба к вам т. т. Пятницкий и Миф; 1) По больше обратить, ваше внимание на работу нашей партии, реагировать на все отклонения от линии партии. 2) Ускорить приезд т. Черномордика. Если почему – либо он не будет дальше работать в Монголии, то ускорить приезд нового представителя Коминтерна. По моему мнению, т. Черномордик вел правильную линию и значительно помог нашей партии в очень сложной обстановке. Представитель Коминтерна нужен нашей партии, как вода и воздух. 3) Настаиваю сделать все возможное сделать устойчивым наличный состав партийного инструктора. Просьба эта является не только моей личной просьбой, но она отражает целиком волю всей партии.

С тов. Приветом : BADARKA

Бадархо Секретарь ЦК МНРП. 5 / III – 1932

Подпись и дата воспроизведены красными чернилами (латинскими и старомонгольскими правами).

Тов. Миф, я считаю, что вся та вольнынка, которая у нас имеется, она свое начало [берет] оттуда и от тех явлений, о которых когда-то я писал вам. Вам это надо иметь ввиду всегда при разрешении того или другого вопроса.

BADARKA /Бадархо/

Помета /перевод с монгольского/ РЦХИДНИ. Ф. 495. оп. 152. д. 137. л.10-18. Подпись сделана латинскими буквами красными чернилами.“

Монгол орчуулга

“Та нарын зүгээс ирсэн Хятадын нөх. Зян Жэ Мин буюу өөр овгоороо Лю Чи Сан Улаанбаатарт буунгуутаа Төв Хороон дээр ирсэн асуудал байна. Түүний золгүй явдал бол тэр хэн нэгэн өвөрмонгол болох Өлзий Бадрах гэгчийг өөрийн орчуулагчаа болгон өөртөө дагуулсан явдал нь гай болсон гэлтэй. Өлзий Бадрах хэмээх өвөрмонголыг манай талаас Японы түрэмгийлэгчидийн болзошгүй тагнуул туршуул байж болно хэмээн сэжиглэж байсан билээ. Анхны ярилцлага дээр л миний зүгээс Лю Чи Санд хандаж, өөрийнх нь талаар Коминтернээс ямар нэгэн мэдээ ирээгүй бөгөөд Коминтернээс түүний талаар хүсэлт тавьж, хариу ирсэний дараа л түүнтэй ярилцах болно хэмээн мэдэгдсэн билээ. Мөн өдөр Н.Охтиныг Москва руу шифр илгээж, асууж өгнө хэмээн хүсэлт тавьсан юм. Үүний дараа гурав хоногийн дараа тэр Коминтернээс цахилгаан хүлээн авч, БНМАУ-аар дайран, ийм нөхөр Хятад руу Хятадын 29-р корпустай холбоо тогтоолгохоор илгээсэн юм гэсэн.

Энэ ярианы үеэр нөх.Нацов байлцсан бөгөөд магадгүй, миний¹⁴ Охтинтой хийсэн яриаг санаж байж магадгүй. Үүний дараа, миний бие бусад хоёр нарийн бичгийн дарга нар нөх. Дэмид болон Лувсаншарав нартай ярилцаж, энэ Хятадын нөхөрт цааш даа явахад нь туслах нь зүйтэй хэмээн тохиролцсон юм. Энэ үеэр, хэрэг явдал шал ондоо байдалд хүрч, намайг Охтинтой ярилцсаны дараа, 2-3 хоног өнгөрөөд хятадтай хамт ирсэн нөхрийн хамтаар нөх. А ялангуяа Намсрай (Дотоодыг Хамгаалахын дарга), Дубровский (Дотоодыг Хамгаалахын зааварлагчийн орлогч), Шеко (Ерөнхий Штабын дарга), нөх. Дэмид болон Жигжиджав нар хамт хүрэлцэн ирж, энэ Хятадын нөхрийг, Японы тагнуул хэмээн баривчлахыг шаардсан юм.

Миний бие эдгээр нөхдийг, баривчлахаасаа өмнө Коминтерн болон Хятадын Коммунист Намын Төв Хорооноос хүлээн авсан цахилгаан бүхий Охтинтой ярилцахыг санал болгосон билээ. Дараа өдөр нь над дээр Охтин янз бүрийн асуудлаар ярилцахаар хүрэлцэн ирсэн юм. Ярианы үеэр би, Хятадын нөхрийг баривчлан авсаныг мэдсэн боловуу хэмээн асуусан юм. Тэр миний

¹⁴ Миний гэдэг нь МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Ө.Бадрахыг хэлж буй.

асуултад хариулах даа, тэр энэ хятад нөхрийг баривчлагдсаныг мэдэж байгаа болно гэсэн. Тэр миний асуултад хариулахдаа, “нөх.Дубровский түүнийг баривчлан, зөв юм хийж” гэжээ. Нөх. Охтин надад илэрхийлсэнээр бол, Москвагаас ирсэн хятад Японы маш нарийн тагнуул байжээ гэсэн. Би энэ мэдээллээс ихэд самгардсан бөгөөд учир нь хэдхэн өдрийн өмнө л Коминтерн ирүүлсэн цахилгаан утсан даа түүнийг өөрийн хүн хэмээн мэдэгдсэн байсан, гэтэл одоо “Японы маш нууц тагнуул болчихдог”. Магадгүй, энэ хятадын хувьд Коминтерны зүгээс ч, МАХН-ын Төв Хорооны зүгээс ч (ялангуяа миний бие түүнтэй ярилцсан байсан) алдсан байх магадлалтай болов уу. Гэлээ гэхдээ л, би өөрөө Коминтернээс тухайн цаг үед Москвад байсан Гэндэн болон Шижээгээр дамжуулж лавлахаар шийдвэрлэсэн. Гэндэн болон Шижээгээс Коминтернээс Монголын Намд үнэхээр түүнийг Хятад руу гарахад нь дэмжлэг үзүүлнэ үү хэмээн хүсэж байна гэсэн билээ. Магадгүй, одоо Дубровский болон Охтин нар өөрийн шугамаар цахилгаан утас хүлээн авсан байх бөгөөд энэ хятад нөхрийн талаар буй за. Түүнийг одоо баривчилгаанаас чөлөөлсөн. Хэдэн хоногийн дараа дамжуулан гаргах болно. Хэрвээ энэ хүн Коминтерны болон Хятадын Коммунист Намын Төв Хорооны ажилтан мөн юм бол, маш эвгүй л хэрэг явдал болжээ. Миний үзэж байгаагаар бол, энэ нөх. баривчлан авсаны бурууг Охтин болон Дубровский нар л хариуцах ёстой болов уу. **Нөх. ёсоор мэндчилсэн BADARKA ”**

Ийнхүү дээр дурьдсан цахар, ХКН, БХК/б/Н-ын гишүүн, Өвөрмонголын харьяат, цахар Ө.Бадрах, мөн МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга, дөрвөд Ө.Бадрах нар нь тус даа хоёр өөр хүн болох нь тодорхой байна.

Дүгнэлт

1. МАН, МАХН-ын түүхэнд Өлзийтийн Бадрах нэр бүхүй дөрвөд, МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Ө.Бадрах, мөн Өвөрмонголын харьяат, цахар, ХКН, БХК/б/Н-ын гишүүн ийм хоёр Өлзий Бадрах үйл ажиллагаагаа явуулж ирсэн байх юм. Судлаач эл асуудлыг энэ өгүүлэлд эрдэм шинжилгээний хүрээнд анх удаа гаргаж тавихыг хичээсэн болно.

2. МАН-ын 3-р их хурал дээр сандал дээр гаран хашгирч, Солийн Данзанг үүрэгт ажлаас нь буулгасан Ө.Бадрах бол “цахар”, нийслэлийн намын сургуулийн сонсогч “Өвөрмонгол”-оос ирсэн Ө.Бадрах байв. Гэхдээ мөн энэ хурал дээр нөгөө Өлзийтийн Бадрах ч гэсэн хотын ХЗЭ-ийнхний хамт байсан юм.

3. Хожим хойно 1930 онд МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Ө.Бадрах нь ХКН, БХК/б/Н-ын гишүүн Ө.Бадрахыг Коминтерний шугамаар ХКН-ын төлөөлөгч нөх. Зян Жэ Мин буюу өөр овгоороо Лю Чи Сан

Монголоор дайрах үед нь уулзан учирч, түүнийг тодорхой хугацаагаар саатуулж ч байсан түүхтэй.

4. Цахар Ө.Бадрах нь Турар Рыскулов нарын зэрэг МАХН, Коминтерний төлөөлөгчдийг Фын Юн Сянтай уулзахаар явахад, мөн Бээжинд очиход орчуулагчаар нь ажиллаж байжээ.

5. Өлзий Бадрах нь МАХН-ын Ө.Бадрахаас ялгаатай болохыг түүний эхнэрийн бичсэн тодорхойлолт бүхүй түүх-архивын нээн баримт гэрчлэх амой. Энэхүү баримтыг МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Өлзийтийн Бадрахын хавтаст хэрэгт хийсэн нь зарим түүхч, судлаачдыг төөрөлдүүлэхэд хүргэдэг байсан бөгөөд эл өгүүлэл нь урьд өмнө Ө.Бадрахаар судалгаа хийж байсан зарим түүхчдийн эргэлзээг тайлахад тус дөхөм болно хэмээн найдаж байна.

6. Бас нэгэн анхаарал татаж буй асуудал бол энэ хоёр Ө.Бадрах нь аль аль нь МАН-ын 3-р их хуралд оролцсон юм бол бие биенийгээ 1932 онд огт танихгүй байсан явдал болно. Тиймээс Ө.Бадрах МАН-ын 3-р их хуралд оролцсон, эсэх асуудлыг цаашид нягтлан судлах шаардлага гарч буй юм. Аль эсхүл Ө.Бадрах зөвхөн БНМАУ-ын анхдугаар их хуралд шууд орон нутгаасаа сонгогдон ирж оролцсон байхыг үгүйсгэж боломгүй. Энэ талаар Ө.Бадрахыг судлаачид огт дурьдаж байсангүй бөгөөд ихэнх судлаачид түүнийг МАН-ын 3-р хуралд оролцсон хэмээн үздэг.

Abstract: Report about Ulziit Badrah. Who had are simmlare name of the Mongolian lider of leftist group in the MRP. Ulzii Badrah was communist of China and member of Chine-s Kommunist Party and Kommunist Party /bolishevik/ of Soviet Union.

Зохиогчдын танилцуулга

1. Г.Ариунболд. БХЭШХ-ийн судлаач, докторант.
2. Д.Базардорж. БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн докторант.
3. Ч.Баянжаргал. Эдийн засгийн ухааны доктор (Ph.D) профессор.
4. Т.Билэгсайхан. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр.
5. Д.Бум-Очир. МУИС, НШУС-ийн Нийгэм соёлын антропологиин тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), профессор.
6. Д.Дашдулам. МУИС, НШУС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор.
7. Ц.Жамбалсүрэн. МУИС, НШУС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (Sc.D), профессор.
8. О.Иноүэ: Inoue Osamu. Япон улсын Шиманэ мужийн их сургуулийн профессор.
9. Б.Леви: Benjamin Levey. АНУ-ын Харвардын их сургуулийн докторант.
10. Х.Мөнхбаяр. Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, докторант.
11. Ж.Наранчимэг. Монголын Үндэсний музейн эрдэм шинжилгээний ажилтан, магистр
12. Б.Нацагдорж. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр.
13. З.Нинжбадгар. МУБИС, Түүх, Нийгмийн ухааны сургуулийн докторант.
14. Г.Одбаяр. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр.
15. О.Оюунжаргал. МУИС, НШУС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (Ph.D).
16. Х. Өрнөх. МУИС, НШУС-ийн Түүхийн тэнхимийн докторант.
17. Б.Ринчинноров. МУИС-ийн НШУС-ийн Түүхийн тэнхимийн магистрант.
18. Д.Сүхбаатар. МУИС, НШУС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор.
19. Л.Чулуунбаатар. МУИС, НШУС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (Ph.D), профессор.